



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/178

Ховд

┌ Жуух бичгээр шагнах тухай ┐

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 98 жилийн ойн баярыг тохиолдуулан Эх орон, ард түмнийхээ төлөө өргөсөн тангарагтаа үнэнч байж, албан үүргээ нэр төртэй гүйцэтгэн Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх үйлсэд хамт олноо манлайлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн Оператив тасгийн оператор, хошууч М.Унат, Холбооны нууцалсан хэрэгслийн бичиг баримтын техникч, ахлах ахлагч С.Сувданцэцэг, эмнэлэгийн ариутгалын бүлгийн химичин жолооч, ахлагч Б.Доржсүрэн, талхан цехийн талх баригч З.Хандсүрэн нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан М.Унат, С.Сувданцэцэг, Б.Доржсүрэн, З.Хандсүрэн нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч, хурандаа /М.Болдбаатар/-д зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ